



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/349

Мөрөн сум

Авто замын урсгал засварын ажил хүлээж  
авах ашиглалтад оруулах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Авто замын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.2, 12.1.4, 12.1.8, 28 дугаар зүйлийн 28.1, Зам тээврийн хөгжлийн сайдын 2018 оны 49 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хөвсгөл аймгийн Хатуу хучилттай авто замын тэмдэг тэмдэглэгээг сайжруулах /Мөрөн сум, төв зам/ ажлыг хүлээж авах ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Б.Энхжаргал

(Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Х.Даваасүрэн

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)

Ж.Жавзанпагма

(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн дарга)

Ё.Ариунзаяа

(Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын Авто тээвэр, усан замын хяналтын улсын байцаагч)

Б.Ганзориг

(Аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн ахлах зохицуулагч)

Д.Оюун-Эрдэнэ

(“Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГазрын ерөнхий инженер)

Ц.Оюун-Эрдэнэ

(Аймгийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын Хөгжлийн бэрхшээлтэй иргэний асуудал хариуцсан мэргэжилтэн)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

С.Баярхүү

(“Хөвсгөл зам” ХХК-ийн инженер)

Ашиглагч байгууллагын төлөөлөл:

Д.Идэрмөнх (Мөрөн сумын Засаг даргын албан үүргийг  
түр орлон гүйцэтгэгч)

Ш.Баасанпүрэв (Мөрөн сумын Архитектор, дэд бүтэц,  
нийтийн тээвэр хариуцсан мэргэжилтэн)

С.Мөнх-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК-  
ийн Захирал)

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Баасанжав (Газрын харилцаа, барилга хот  
байгуулалтын газрын мэргэжилтэн)

2. Авто замын урсгал засварын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд 2022 оны 10 дугаар сарын 19-ний өдрийн дотор танилцуулахыг Комиссын дарга (Б.Энхжаргал)-д даалгасугай.

3. Авто замын урсгал засварын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Баасанжав) -д үүрэг болгосугай.

4. Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилгын ажил хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ш.ИДЭРБАЯСГАЛАН